

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022.07.01

Улаанбаатар хот

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх газрын стратеги төлөвлөгөө байгууллагаас 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг ханган биелүүлэх чиглэлээр дараахь ажил, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Авлигатай тэмцэх газраас Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага /IDLO/-тай авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах зорилгоор “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр, Румын Улсын Авлигатай тэмцэх үндэсний газартай “Хамтран ажиллах санамж бичиг”-ийг, төрийн бус байгууллагаас авлигатай тэмцэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах чиглэлээр гаргаж байгаа санал, санаачилгыг дэмжиж Монголын Хөлбөмбөгийн холбоотой 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр “Хамтын ажиллагааны Санамж бичиг”, хэвлэл мэдээллийн байгууллагатай дээрх чиглэлээр хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, инновацыг нэвтрүүлэх, хамтын ажиллагаа түншлэлийн харилцааг өргөжүүлэх чиглэлээр Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз (МҮОНРТ)-тэй 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр “Хамтын ажиллагааны Санамж бичиг”-ийг тус тус байгуулав.

Монгол Улсаас хүргүүлсэн Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн тайлангийн хүрээнд нэмэлт мэдээлэл авах, тодруулга авах, хамтран ажиллах буюу Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хоёр болон тавдугаар бүлгийн хэрэгжилтийг үнэлэх шинжээчдийн үнэлгээний уулзалт, хэлэлцүүлэг, холбогдох бусад ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган, дэмжлэг үзүүлж, хариуцан ажиллав. Үнэлгээг хийхээр НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын 2 шинжээч, Буркина Фасо Улсын 3, Сингапур Улсын 2 шинжээч хүрэлцэн ирсэн бөгөөд үнэлгээний уулзалтад Сангийн яам, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, ЗГХЭГ, ТХААГ, ТАЗ, ҮАГ, ШЕЗ, УДШ, УЕПГ, ЦЕГ зэрэг төрийн байгууллага, ТББ, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага зэрэг нийт 36 байгууллагын төлөөлөл оролцлоо.

Бүгд Найрамдах Франц Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Сэбастиен Сүрүнтэй Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа 2022 оны 6 дугаар сарын 8-ны өдөр уулзаж, хоёр орны авлигатай тэмцэх ажлын ололт амжилт болон эрх зүйн хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

Дэлхийн Банкны Шударга байдлын дэд ерөнхийлөгчийн газар (INT)-ын Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн мөрдөн шалгах албаны дарга Ноён Ришели Ломакстай уулзалт хийж цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцож, Дэлхийн банкны санхүүжилттэй төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан нягт хамтран ажиллахаар, АНУ-ын Мянган сорилтын корпорацийн Компактийн үйл ажиллагаа хариуцсан захирал Кэвин Митчэлл, Авлига, хээл хахуулийн асуудал хариуцсан ахлах захирал Кристофер Уильямс, Монголын Мянган сорилтын сангийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Уранчимэг тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзалт хийж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцож, Компакт гэрээний төслийн хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлд хамтран ажиллахаар тохиров.

Авлигын эсрэг олон улсын академи (IACA)-аас дэвшүүлсэн Авлигын эсрэг дэлхийн хотуудын сүлжээ буюу “Global Anti-Corruption Cities Network” шинэ санаачилгад Улаанбаатар хот нэрдэн орохоор саналаа илэрхийлж, Авлигатай тэмцэх газар уг сүлжээний зохицуулагч байгууллагаар ажиллахаар боллоо.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас 2021 оны 12 дугаар сард танилцуулсан “Авлигын эсрэг боловсрол олгох, залуучуудыг чадавхижуулах санаачилга”-тай

хамтран ажиллах талаар уулзалт зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. Уулзалтаар тус санаачилгын авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсруулсан материалыг Монгол Улсын авлигын эсрэг боловсрол олгох, соён гэгээрүүлэх ажиллагаанд ашиглахаар тохиролцож, эхний ээлжинд бага, дунд, дээд боловсролын сургалтын модулийг хүлээн аваад байна.

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдөр баталсан Транспэрэнси Интернэшнл байгууллагаас гаргадаг Авлигын төсөөллийн шалгуур үзүүлэлт /индекс/-ийг сайжруулах зорилго бүхий ажлын хэсэгт тус газрын Дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал томилогдон ажиллаж байгаа ба тус ажлын хэсгээс хэрэгжүүлэх эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэлтийг хангах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг хэрэгжүүлж, тайланг мэдээг хүргүүлээд байна.

Зорилтот хяналт шалгалтын хүрээнд Авлигын эсрэг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд “Эрдэнэс Монгол” ХХК-д газрын Дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг ажилласан ба ажлын нэгдсэн тайлан мэдээг, холбогдох саналыг 3 дугаар улиралд нэгтгэн танилцуулахаар ажиллаж байна.

Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан “Авлигын эсрэг үндэсний чуулган-2021”-аас гарсан зөвлөмжийг, арга хэмжээний төлөвлөгөөний хамт эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Дэлхийн банк болон Монгол Улсын Засгийн газар хоорондын Ухаалаг засаг төслийн хүрээнд Байгууллагад ашиглагдаж байгаа meduuleg.iaac.mn, iad.iaac.mn; e-office, smart.iaac.mn, search.iaac.mn, xasxom.iaac.mn гэх цахим системүүдийг интеграцичлах, үйл ажиллагааг хөнгөвчлөх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, тоног төхөөрөмжийг шинэчлэх, системийн хэвийн найдвартай аюулгүй байдлыг хангах ажлыг эхлүүлсэн бөгөөд тайлант хугацаанд төслийн багтай байнгын нягт холбоотой хамтран ажиллаж байна. Төслийн хүрээнд тендер сонгон шалгаруулалтын ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулан, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Дижитал воркс” ХХК-ийг шалгарч, “Мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын цахим систем”-ийн програм хангамж, өгөгдлийн сан, техник хангамж болон сүлжээний зохион байгуулалтын хувьд бүрэн шинэчлэх зорилгын хүрээнд системийг 2 үе шаттай хөгжүүлэхээр ажиллаж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээлэхийн зэрэгцээ хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх, хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэлээ. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан 216 арга хэмжээний гүйцэтгэл 2021 онд 75.0 хувьтай байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 6.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын даалгаврыг боловсруулах чиглэлээр ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарыг олон нийтэд нээлттэй мэдээлэн, ажлын даалгаврыг Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу тус байгууллагын Монгол дахь Суурин төлөөлөгчийн газарт хүргүүлээд байна.

Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг баримтлан “Монгол Улсын авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал”-ын талаарх мэдээлэл, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэгдсэн тайлан, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн мэдээллийг эмхэтгэн Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын дэргэдэх байгууллагууд, яамд, Засгийн газрын агентлагуудад, нийслэлийн болон 21 аймгийн Засаг дарга нарт тус тус хүргүүлэв. Уг мэдээллийн товчийг англи хэл дээр гарган, олон улсын байгууллага, Монгол улсад суугаа гадаад улсын Элчин сайдын яамд, Гадаад харилцааны яам болон МУ-аас гадаад улсад суух Элчин сайдын яамдад хүргүүлэв.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай хууль, Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсэгт нэр бүхий албан хаагчид ажиллаж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлд 22 шүүгчид холбогдуулан хөрөнгө орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлээгүй нь “Шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийг зөрчсөн гэх үндэслэлээр 2021 онд гомдол гаргасныг 2022 онд Шүүхийн ёс зүйн хорооны хуралдаан, тус хорооны бүх шүүгчдийн хуралдаанаар үргэлжлүүлэн хянан хэлэлцэж, нэр бүхий 11 шүүгч ёс зүйн зөрчил гаргасан болох нь тогтоогдсон. Энэхүү нөхцөл байдал, цаашид шүүгч нарын ёс зүй, хууль дээдлэх, үнэнч шударга байх зан суртахууны төлөвшлийг дээшлүүлэх шаардлагатай байгаа талаар Шүүхийн Ерөнхий зөвлөлд мэдэгдлээ.

Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын шалгалтаар “Зөрчилгүй” дүгнэгдлээ.

Хоёр.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын талаар:

2.1 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх хэсэгт заасан “улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих” чиг үүргийн хүрээнд доорхи ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан танилцуулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн бус байгууллагын оролцоог хангах, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, гомдол, санал хүлээн авах, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа болон “Авлигатай тэмцэх газар”, “АТГ-Олон нийтийн төв” фэйсбүүк хуудсыг сурталчлах зорилгоор “Таны эрх, таны оролцоо-авлигад үгүй гэж хэлье” соён гэгээрүүлэх өдөрлөгийг Багануур, Налайх дүүрэгт Төв аймаг, Говьсүмбэр, Дархан-Уул, Сэлэнгэ, Булган, Орхон аймгуудад зохион байгуулав.

Өдөрлөгийн үеэр ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад чиглэсэн шударга ёсны боловсрол олгох хөтөлбөр, иргэд рүү чиглэсэн авлигын хор хөнөөлийг таниулах хөтөлбөрт арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд нийт 3219 хүн ирж оролцсон дүнтэй байна.

Авлигатай тэмцэх газраас авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд Олон нийтийн зөвлөлийн гишүүдийг татан оролцуулах, үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байгаа бөгөөд дээр дурьдсан орон нутагт зохион байгуулсан өдөрлөгт тус зөвлөлийн гишүүд оролцож, хамтран ажиллав.

Нийслэл, дүүргийн Иргэний танхим, Хууль зүйн туслалцааны төвүүдтэй хамтран иргэдэд авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, зөвлөгөө, мэдээлэл өгөх, соён гэгээрүүлэх арга хэмжээг хамтран зохион байгуулснаар тайлант хугацаанд хууль зүйн туслалцааны төвүүдээр дамжуулан давхардсан тоогоор 1,171,608 иргэнд хүрч ажилласан байна.

“Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудад “Шударга ёсны клуб” байгуулах санал санаачилга, үйл ажиллагааг дэмжсэнээр Нийслэлийн ерөнхий боловсролын 24, 12, 1, 40, 32, 84 дүгээр сургууль, Багануур дүүргийн ерөнхий боловсролын лаборатори цогцолбор сургууль, Хэнтий аймгийн Бор-Өндөр цогцолбор, Хэрлэн 1, Хэрлэн 2 дугаар сургууль зэрэг 10 сургуульд “Шударга ёсны клуб” байгуулагдан тус байгууллагаас клубын үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, сургалт, сурталчилгаа хийх ажлыг хамтран зохион байгуулж байна.

Батлан хамгаалах яамтай хамтран Зэвсэгт хүчний жанжин штабын тусгай хүчний командлалын харьяа 013, 084, 150, 350, 345 дугаар нэгтгэл ангиудын бие бүрэлдэхүүнд сургалт, соён гэгээрүүлэх өдөрлөг, Үндэсний Батлан хамгаалах Их сургууль, Дотоод хэргийн Их сургуультай хамтран “Таны эрх, таны оролцоо- өнөөдрийг маргаашийн бахархал болгоё” соён гэгээрүүлэх өдөрлөг, МУИС-ийн “Бизнесийн сургууль”-ийн оюутнуудтай хамтран “Таны эрх, таны оролцоо: Залуучууд авлигыг тэвчихгүй” арга хэмжээг зохион байгуулав.

Өвөрхангай, Хөвсгөл, Дорноговь, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран “Зөв зөвд шударга зөв” аяныг зохион байгуулахад дэмжин чиглүүлж, арга зүйн удирдлагаар ханган ажиллав.

Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолбортой хамтран хүүхэд багачуудад хэрхэн шударга, зөв байх сургалт хүмүүжлийг олж авах талаар харилцан ярилцаж, шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх зорилго бүхий “Шударга байх хамгийн гоё” арга хэмжээг зохион байгуулсан ба тус арга хэмжээнд тус цогцолборт амарч буй 400 гаруй хүүхдийг хамрууллаа.

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. 2021 оны үнэлгээгээр 21 аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл дунджаар 77.6 хувь, яамдынх 76.0 хувьтай үнэлэгдэв.

Төрийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээнд тандалт хийх, хүнд суртал чирэгдэл үүсгэж байгаа эсэх, ил тод байдлыг хангаж байгаа эсэхийг судлан тогтоох, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авах ажлын хүрээнд яам агентлагууд, аймгуудын цахим хуудасны ил тод байдалд хагас жилийн байдлаар дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлээд байна.

Шударга ёсны агуулгыг хичээлийн хөтөлбөрт тусгах, сургалтын хөтөлбөр боловсруулах, сургагч багшийг бэлтгэх, тэдгээрээр дамжуулж сурагч, эцэг эхэд нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах, тэдэнд дэмжлэг үзүүлэх зорилгоор ерөнхий боловсролын багш нарын дунд хичээлийн хөтөлбөрийн уралдааныг 2 үе шаттайгаар зарласан. Уралдаанд нийт 251 хөтөлбөр ирүүлснээс анхан шатны шалгаруулалтыг хийж, 2 дахь шатанд тэнцсэн 96 хөтөлбөрийн шалгаруулалтыг Боловсролын ерөнхий газартай хамтран хийснээс бага, дунд, ахлах анги гэсэн ангиллаар 15 хөтөлбөрийг шалгаруулж, оролцогчдод шагналыг гардууллаа.

2.2 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь хэсэгт заасан “авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх;” чиг үүргийн хүрээнд:

Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн санхүүжилтээр 2021 онд хэрэгжүүлсэн ажлыг тайланг хүргүүлж, мөн санхүүжилтээр 2022 онд хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Аймгуудын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн сургагч багш нарын авлигын эсрэг сургалт, сурталчилгаа хийсэн ажлыг дүгнэх, авлигын эсрэг сургалт, сурталчилгааны ажлын орон нутагт зохион байгуулахад гарч буй хүндрэл, бэрхшээлийн талаар ярилцах, 2022 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэх зорилгоор сургагч багш нартай цахим уулзалт зохион байгуулав.

2.3 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. 4 дэх хэсэгт заасан “төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;” чиг үүргийн хүрээнд авлигын эсрэг хууль тогтоомж болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэн, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллаж байна.

Монголын Хөлбөмбөгийн холбоотой хамтран ажиллах Санамж бичгийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Нийтийн хөлбөмбөг” арга хэмжээнд “Зөв шүүлт-шударга тоглолт” иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх өдөрлөгийг зохион байгуулж, багийн спортоор дамжуулан үнэнч, шударга, зөв дадалд сургах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, гомдол, санал хүлээн авах, тэмцээн уралдаан зохион байгуулах, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зэрэг арга хэмжээг зохион байгууллаа. Өдөрлөгт 1500 гаруй хүн оролцсон байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд төрийн 665 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээр төрийн албаны хүнд суртал, чирэгдлийг арилгах ач холбогдолтой ажил болсон талаар олон нийтэд сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэднийг татан оролцуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх, гомдол, санал хүлээн авах, “Авлигатай тэмцэх газар”, “АТГ-Олон нийтийн төв фэйсбүүк” хуудсыг сурталчлах зорилгоор Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Е-Монголиа академитай хамтран “Хүнд сурталгүй цахим үйлчилгээ” өдөрлөг зохион байгуулав. Өдөрлөгөөр Байгууллагаас гаргасан 10 төрлийн ном, гарыг авлагыг цахим хэлбэрт шилжүүлсэн тухай, “Сонголт” видео контентын өрнөлийг нь үзэгчид өөрсдөө сонгох боломжтой хэлбэрээр боловсруулсан тухай сурталчлах, “Хүнд суртал,

чирэгдэлгүй үйлчилгээ” танилцуулга брошюр /3000ш/-ийг түгээх, “Шударга ёсны клуб”-ын сурагчид жүжигчилсэн тоглолт хийх зэрэг шинэлэг ажлуудыг зохион байгууллаа. Өдөрлөгт 600 хүн оролцож, мэдээлэл авсан байна.

“Монголын шүүгчдийн холбоо” ТББ-аас гаргасан саналыг хүлээн авч, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн “Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах” 5 дугаар зорилтыг хэрэгжүүлэх, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүгчдээс “Шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийг баримтлан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ёс зүйн дүрмээр хүлээсэн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлдэг байх ёс зүйн хэмж хэмжээг баримталдаг байх зэрэг асуудлаар санал солилцох зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, цаашид хамтран ажиллахаар тогтов.

2.4 Хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.2 дэх хэсэгт заасан “авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах” чиг үүргийг хангах хүрээнд:

Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны А/183 дугаар "Заавар батлах тухай" тушаалаар баталсан "Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хянах заавар"-ын дагуу нийт 26 шийдвэр, дүрэм, журмыг хянаснаас 21 нь хэм хэмжээний актад тавигдах ерөнхий ба тусгай шаардлагыг хангаагүй нөхцөл байдал тогтоогдсон. Иймд тухайн дүрэм, журмын бүхэлд нь хүчингүй болгох тухай 10, хэсэгчлэн хүчингүй болгох 6, өөрчлөлт оруулах 1, захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэх 5 саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Хүргүүлсэн саналын дагуу 2 шийдвэр хүчингүй болж, 1 шийдвэрийг хуульд нийцүүлэх арга хэмжээ авч байгаа тухай хариу ирүүлээд байна.

Төрийн болон төрийн өмчит байгууллагын, тухайлбал, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Дулааны гуравдугаар цахилгаан станц, Төв аймгийн Зуунмод сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн ёс зүйн дүрэм, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрмийг хуульд заасан үндэслэлээр хянаж, холбогдох саналыг хүргүүлэв.

2.5 Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь хэсэгт заасан “Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаархи мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх” чиг үүргийн хүрээнд дараахь ажил, арга хэмжээг зохион байгуулав. Үүнд:

Тайлант хугацаанд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг ухуулан сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг тайлбарлан таниулах зорилгоор “Түрийвч”, “Цахим хичээл” “Сонголт”, “Үйлийн үр хаяг андуурдаггүй юм” сэдэвт богино хэмжээний 4 видео контент, “Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд зөв дадал, шударга ёсны тухай 11 төрлийн видео шторк бүтээлээ.

Дээрх видео контент, шторкуудыг Улаанбаатар хотын 7 байршилд 7 лед дэлгэцээр, мөн R&P Entertainment TV, Оргил TV, Богц TV, Гэгээ TV, Дуу шүлэг TV, Сэдэв TV зэрэг онлайн телевизүүдээр дамжуулан олон нийтэд түгээх, сурталчлах ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулав.

Улаанбаатар хот, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг “Тэнгис”, “Гэгээнтэн”, “Prime cinerplex”, “Өргөө-1, 2, 3”, Дархан-Уул, Орхон аймгийн Өргөө нийт 9 кино театраар үйлчлүүлэгчдэд зөв дадал, шударга ёсыг хэвшүүлэх болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээрх видео шторк, богино хэмжээний контентыг толилуулж байна. Радиогийн нэвтрүүлгээр дамжуулан иргэдийн авлигын эсрэг мэдлэг, мэдээллийг дээшлүүлж, иргэдийн оролцоог хангаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой мэдээллийг хүргэх зорилгоор Дэлхийн монголчуудын радио-“MGL” радиотой хамтран авлигаас урьдчилан сэргийлэх, түүний хор хөнөөлийг танин мэдүүлэх чиглэлээр “Нэг дусал” контентыг нэг удаад 3 минут үргэлжлэхээр бэлтгэн өдөрт 9

удаагийн давталтайгаар сонсогчдод хүргэж байна. Тайлант хугацаанд 100 сэдвийн хүрээнд контентыг цувралаар хүргэсэн байна.

МҮОНТ-тэй хамтран 14 хоног тутам “АТГ-ын мэдээлэл” нэвтрүүлгийг 7 хоног бүрийн тогтсон цагт 20 минутаар бэлтгэн орон даяар түгээж байна. Тайлант хугацаанд 12 удаагийн дугаарыг тодорхой сэдвээр бэлтгэн МҮОНТ төдийгүй “Малчин”, “Лайв” телевизээр болон байгууллагын фэйсбүүк хуудсаар олон нийтийн хүртээл болгов.

Боловсрол” телевизтэй хамтран ажиллаж, урьдчилан сэргийлэх сурталчилгааг нэвтрүүлэхийн зэрэгцээ тус телевизийн “Edutainment TV” фэйсбүүк хуудсанд (1,017,374 дагагчтай) байгууллагын мэдээ мэдээллийг байршуулж байна.

Тайлант хугацаанд Ерөнхий боловсролын бага ангийн сурагчдад зориулан сэтгэхүй хөгжүүлэх бодлого, математик үг хэллэгээр дамжуулан шударга ёсны үзэл санааг ойлгон, зөв буруу үйлийг ялган, найз нөхдөдөө зөв үлгэр дуурайлал үзүүлэхэд төлөвшүүлэн авлигын эсрэг боловсролын суурь мэдлэгийг олгох “Шударга ёс: Сэтгэхүй хөгжүүлэх бодлого” гарын авлага /500ш/, “Шударга тоглоё” хүүхдэд зориулсан ном зурагт ном /3500ш/, “Шударга тоглоё” буддаг ном /3500ш/, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн 12 төрлийн хориглолт, хязгаарлалтын танилцуулга, брошюр /12000ш/, “110” дугаарын утасны сурталчилгаа бүхий авто стикер /44400ш/, “Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол хэрхэн гаргах вэ?” /3000ш/, “Иргэн та авлигын эсрэг юу хийж чадах вэ?” /3000ш/, “Хүнд сурталгүй төрийн үйлчилгээ” брошюр /3000 ш/-ыг хэвлүүлэн түгээв.

“DM SKY” ХХК-тай хамтран галт тэрэгний 40000 тасалбар дээр авлигын зөрчил, гэмт хэргийн талаар мэдээлэл хүлээн авах тусгай дугаар /110/-ын сурталчилгааг хэвлүүллээ. “Нарру” ХХК-тай хамтран 228 орон сууц, албан байгууллагын лифтэнд байрлах дэлгэцээр иргэдийг соён гэгээрүүлэх чиглэлээр видео, контентийг тогтмол нэвтрүүлж байгаа ба давхардсан тоогоор 14294 өрхийн 2,930,270 хүнд хүрсэн дүнтэй байна. Авлигын эсрэг сурталчилгаа бүхий мэдээллийн самбарыг Баянгол дүүргийн 1, 3, Баянзүрх дүүргийн 3, 7, 26 хороодын орон сууц, хотхоны 816 орцонд байршуулснаар 20471 өрхийн 70,964 иргэнд хүрсэн дүнтэй байна.

Мөн авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах, зөв шударга зүйлд иргэд, олон нийт, төрийн албан хаагчдыг уриалах, авлигын эсрэг үйл ажиллагаанд тэднийг татан оролцуулах зорилгоор зорилтот бүлгүүдэд зориулсан видео контентуудыг цахим хуудас, пэйжээр, мөн телевизүүдтэй хамтран түгээх ажлыг зохион байгуулж байна.

Urug.mn сайттай хамтран Авлигатай тэмцэх газраас гадна Улсын Ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яамны төлөөлөл, судлаачдыг оролцуулан “Авлигын хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх нь зөв үү” сэдвээр 02 дугаар сарын 18-ны өдөр, “Авлигын гэмт хэргийн ялын бодлого” сэдвээр 2022 оны 04 дүгээр сарын 28-нд тус тус хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлгийг “Тэнгэр” телевиз, “Өрөг сайт”, түүний социал сувгууд болон байгууллагын албан ёсны цахим хуудас, фэйсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэв.

2022 оны эхний хагас жилийн байдлаар авлигын хор аюулыг ухуулан таниулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 129 удаагийн сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулж, 23,187 хүнийг хамруулсан байна. Тухайлбал, 3 удаагийн модулийн давтан сургалтад төрийн өмчит хуулийн этгээдийн 54 удирдах албан тушаалтан, төсөв санхүүгийн асуудал хариуцсан 48, дотоод хяналт, аудитын асуудал хариуцсан 46, нийт 148 албан тушаалтныг суралцууллаа.

Хувийн хэвшлийн байгууллагуудыг чадавхжуулах авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хувийн хэвшлийн оролцоо, анхаарах асуудал сэдвээр сургалтыг үе шаттай зохион байгуулж, Дорнод аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн холбоо”, Өвөрхангай аймгийн “Оновчтой шийдэл”, Дорнод аймгийн “Буйр нуур”, Ховд аймгийн “Ховдын толь сонин”, Орхон аймгийн “Эрдэнэт хүмүүний нийгэмлэг”, “Буурь нуур, Халх гол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн НҮТББ”, “Эрдэнэт хүмүүний эв нэгдэл” зэрэг ТББ-ын төлөөлөл, Эрдэнэс Таван Толгой ХК, Скайтел ХХК, Түмэн төмөрт ХХК, ЧПМ ХХК, Жакаранда ХХК, МУИС-ийн Бизнесийн сургууль, Сити их сургууль /20/, Говь ХХК

/захирлууд 30/, Капитрон банк /удирдлага, тооцооны төвийн захирал, эрхлэгч, банкны ахлах менежер, эдийн засагч 131/, Гаалийн бүрдүүлэлтийн аж ахуйн нэгж /195/, Зууны мэдээ сонин, /сэтгүүлч 12/, Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ-ын /6/ нийт 478 хүнийг хамруулсан.

Нийслэлийн 9 дүүргийн 176 хорооны 1720 хэсгийн ахлагч нарыг чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулж байгаа ба тайлант хугацаанд Чингэлтэй дүүргийн 24 хорооны 220 хэсгийн ахлагчийг тус сургалтад хамрууллаа.

“Монголын хэвлэлийн хүрээлэн” ТББ-тай хамтран “Авлигатай тэмцэхэд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн үүрэг оролцоо” сэдэвт сургалт, семинарыг 2 удаа зохион байгуулж, нийт орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын 69 сэтгүүлчийг, Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага /IDLO/-ын төслийн санхүүжилтээр Хэвлэлийн хүрээлэн, Хэвлэл мэдээллийн зөвлөл, “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагатай хамтран эрэн сурвалжлах сэтгүүлчдэд зориулсан сургалтыг зохион байгуулж, энэ чиглэлээр ажилладаг 54 гаруй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг хамруулсан юм.

Сургалтаар эрэн сурвалжлах сэтгүүл зүй ба уламжлалт сэтгүүл зүйн ялгаа, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн арга техникийн суурь мэдлэг, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн олон улсын туршлагын талаарх ойлголт, интернэтийг эрэн сурвалжилгад ашиглах чадвар, хөрөнгө, орлогын мэдүүлгийг үнэн зөв судалж, мэдээлэх, Нийтийн мэдээллийн тухай хуулийн анхаарах асуудлууд, сэтгүүлчийн аюулгүй байдал, авлигын гэмт үйлдэлтэй тэмцэхэд сэтгүүлчийн үүрэг оролцоо, АТГ-ын олон нийттэй харилцах бодлого зэрэг сэдвээр хичээл заасан байна. Түүнчлэн Сургалтад оролцогчид “Авлигатай тэмцэхэд хэвлэлийн мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн үүрэг оролцоо”, “Мөс хагалах хэлэлцүүлэг: Мэдээллийг яагаад нягтлан шалгах ёстой вэ?”, “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нягтлан шалгах сэтгүүл зүй болох тухай”, “Уламжлалт сэтгүүл зүйгээс ялгарах шинж чанар”, “Эх сурвалжийн найдвартай байдал, эх сурвалжийн таамаглал Багийн ажил: Таамаг дэвшүүлэх дасгал Баримт гэж юуг хэлэх вэ?”, “Баримтыг нягтлан шалгах алхмууд, түлхүүр асуулт, логик дараалал”, “Интернэтийг сэтгүүл зүйд ашиглах нь Google-д мэдээлэл хайх эхний алхмууд болон стратеги”, “Худал, гуйвуулсан, бүрэн бус мэдээллийн ангилал”, “Худал мэдээлэл хэмээх ойлголтын тухай”, “Нийгмийн мэдээллийн сүлжээн дэх худал мэдээллийн нийтлэг шинж чанар”, “Эвлүүлсэн видеог нягтлан шалгах арга, зарим апп, tools, дасгал ажил”, “Өгөгдөл гэж юуг хэлэх вэ?”, “Дата сэтгүүл зүйн удиртгал” сэдвээр суралцаж, “сургалтын дэвшилтэд аргыг ашиглан хэлэлцүүлэг өрнүүлсэн ач холбогдол бүхий сургалт болсон болохыг оролцогчид дүгнэсэн байна.

Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багш бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж байна. Үүнд: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран 21 аймагт авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах 35 сургагч багшийг бэлтгэсэн бөгөөд сургагч багш нар 55 удаагийн сургалтыг зохион байгуулж 5730 төрийн албан хаагчийг, авлигын соён гэгээрүүлэх чиглэлээр 5 удаагийн өдөрлөг зохион байгуулж, 2576 иргэн хамрагдсан байна. Цагдаагийн байгууллагын сургагч багш нарын давтан сургалтад 52 сургагч багшийг хамруулсан.

21 аймгийн Хууль зүйн туслалцааны төвийн 52 өмгөөлөгчийг анхан шатны сургагч багшаар, нийслэлийн төрийн өмчийн 29 сургуулийн багшийг сургагч багшаар бэлтгэж, Боловсрол хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран Өвөрхангай аймгийн бүх сумдын ерөнхий боловсролын сургуулийн багш нар 80 гаруй багш, нийгмийн ажилтныг сургагч багшаар бэлтгэхээр анхан шатны сургалтад хамруулаад байна.

Олон нийтийн сүлжээг ашиглан авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчлан таниулах, үнэн зөв мэдээ, мэдээллийг бодит эх сурвалжаас түгээх зорилготой “Авлигатай тэмцэх газар”, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, төрийн албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх, ёс зүйг дээшлүүлэх, байгууллагын соёлыг тогтоох зорилготой “АТГ-Олон нийтийн төв” фэйсбүүк хуудсыг хөтлөн хөгжүүлэлтийг тухай бүр хийж байна. Тус фэйсбүүк хуудаснуудын дагагчдын тоо 20,394 хүнээр нэмэгдсэн байна.

“Авлигатай тэмцэх газар” фэйсбүүк хуудсанд видео контент/шторк 83, үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл, инфографик 213 нийтлэл (пост) нийт 296 нийтлэл шинээр оруулж давхардсан тоогоор 2,231,242 хүнд хүрсэн байна. Өдөрт дунджаар 13,048 хүнд авлигын эсрэг

мэдээ, мэдээлэл хүрсэн байна. Фэйсбүүк хуудасны дагагчдын тоо 8642 хүнээр нэмэгдэж 32,971 болсон байна. Өдөрт дунджаар 51 хүн шинээр дагажээ. “АТГ-Олон нийтийн төв” фэйсбүүк хуудсанд тайлант хугацаанд видео контент/шторк 115, үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл, инфографик 193 нийтлэл (пост) нийт 308 мэдээ мэдээлэл оруулж давхардсан тоогоор 3,097,413 хүнд хүрсэн байна. Өдөрт дунджаар 18,114 хүнд авлигын эсрэг мэдээлэл хүргэжээ. “АТГ-Олон нийтийн төв” хуудасны дагагчдын тоо тайлант хугацаанд 11,752 хүнээр нэмэгдэж 59,467 дагагчтай болж, өдөрт дунджаар 69 хүнээр нэмэгдсэн дүнтэй байна.

2.5 Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь хэсэгт заасан “авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх” чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэв.

Тайлант хугацаанд Зам, тээврийн хөгжлийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад тус бүр 2 удаа, Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Хүрээ амаржих газар, Улсын бүртгэлийн Ерөнхий газар, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар, Нийслэлийн боловсролын газарт буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд авлигын шалтгаан нөхцөлийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг арилгахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавьж ажиллах, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх, албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх, түүнд тавих дотоод хяналыг сайжруулах чиглэлээр нүүр тулсан уулзалтуудыг хийн зөвлөмжийг гардуулан өгч, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар Зам, тээврийн хөгжлийн сайдад болон Нийслэлийн Хүрээ амаржих газарт хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн ажлын тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийж байна.

2022 оны эхний хагас жилд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгахаар хуулийн этгээдэд хүргүүлсэн 69 мэдэгдлээс 16 мэдэгдлийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийв. Үүнээс 4 мэдэгдлийн мөрөөр үр дүнтэй арга хэмжээ авч, авлигын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгасан байлаа. Бусад мэдэгдлийн мөрөөр үр дүнтэй арга хэмжээг аваагүй байх тул 5 байгууллагад зөвлөмж, шаардлага хүргүүлээд байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хууль тогтоомж зөрчсөн нийтийн албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар Мөрдөн шалгах хэлтэс, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн 11 шаардлага /албан бичиг/-ын хэрэгжилтийг хангуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, байгууллагын хэмжээнд авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах зорилгоор Сэлэнгэ аймгийн Сайхан суманд байрлах “Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанид, Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, арилгах, таслан зогсооход чиглэсэн арга хэмжээ авах, төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг арилгах зорилгоор Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс болон Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст, Мал эмнэлгийн ерөнхий газарт тус тус ажилласан бөгөөд ийнхүү газар дээр нь ажиллах явцад тогтоогдсон нөхцөл байдалд дүгнэлт хийн зөрчил дутагдлыг арилгах талаар зөвлөмжийг 2022 оны 3 дугаар улиралд хүргүүлэхээр төлөвлөөд байна.

Гүрав. Судалгаа, шинжилгээний ажлын чиглэлээр:

Авлигын эсрэг хуульд заасан чиг үүрэг, байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын болон зорилтот судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар:

• “Авлигын эрсдэлийн үнэлгээ”-г Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монголын төмөр зам ТӨХК, Баянзүрх дүүргийн Газар зохион байгуулалтын албанд хийж, судалгааны дүнг судалгаанд хамрагдсан дээрх байгууллагуудад танилцуулах ажиллагааг зохион байгууллаа.

• “Шударга байдлын үнэлгээний судалгааны мэдээлэл цуглуулах, тайланг бэлтгэж, үр дүнг олон нийтэд мэдээлэх” ажлыг зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эхлүүлж, шалгарсан гүйцэтгэгч нарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар судалгааны мэдээлэл цуглуулах ажил дунджаар 26.3 хувьтай явагдаж байна.

• Жил бүр зохион байгуулагддаг “Хүүхдийн шударга байдлын судалгаа”-нд аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 6492 сурагч, 1410 багш, албан хаагч, 1410 эцэг, эхээс мэдээлэл цуглуулсан ба мэдээлэл боловсруулалт хийж, судалгааны үр дүнгийн тайланг боловсруулах ажил хийгдэж байна.

• Хорооноос иргэдэд үзүүлж буй үйлчилгээ, хороонд хандаж, үйлчилгээ авсан иргэдийн бүртгэл, статистикийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгааг 9 дүүргийн 82 хороог хамруулан гүйцэтгүүлж, судалгааны тайлан, зөвлөмжийг хүлээн аваад байна.

• Авлигатай тэмцэх газрын олон нийттэй харилцах бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг гүйцэтгэсэн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээдтэй хамтран ажиллаж, судалгааны ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавин хамтран ажилласнаар судалгааны тайланг хүлээн авлаа. Тайланд холбогдох санал, мэдээллийг тусган баталгаажуулах ажил хийгдэж байна.

• Авлигын эсрэг соён гэгээрүүлэх арга хэмжээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал боловсруулах”, “Монголчуудын ёс заншил, уламжлал, ахуй, соёлтой нийцсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны арга, хэлбэрийг тодорхойлох”, “Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах соён гэгээрүүлэх үйл ажиллагааны стратеги (2022-2024) боловсруулах”, “Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй олон нийттэй харилцах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүн, ач холбогдлын талаарх олон нийтийн санаа бодлыг судалж, дүгнэлт, зөвлөмж санал боловсруулах (хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх)” 4 төрлийн судалгааны гүйцэтгэл 90 хувьтай байна. Эдгээр судалгааны ажлын үр дүнд суурилан авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны стратеги боловсруулахаар төлөвлөсөн болно.

• Монгол Улс дахь авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийн динамик загвар боловсруулах, ажлын хүрээнд гүйцэтгэл 80 хувьтай байна. Энэ чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа судлаачдын багтай байнгын холбоотой ажиллаж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

• Байгууллагын соёлын нөхцөл байдлын судалгааг зохион байгуулж байна. Судалгаанд хамрагдвал зохих нийт албан хаагчдын 83.0 хувь хамрагдсан бөгөөд судалгааны өгөгдлийг боловсруулж байна. Судалгааны дүнд үндэслэн ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах, тайланг хүлээн авах ажлыг 2022 оны 07 дугаар сард багтаан зохион байгуулахаар төлөвлөсөн болно.

• Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн зохицуулалтад иж бүрэн шинжилгээ хийж, хууль тогтоомжийн өнөөгийн байдал, боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг судалж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зөвлөмж бүхий үнэлгээ, санал боловсруулах ажлыг гэрээгээр гүйцэтгүүлж эхлээд байна.

Дэлхийн Засаглалын Үзүүлэлт (Worldwide Governance Indicators)-ийн 2020 оны үр дүнгийн талаар, Бертелсман сангаас гаргадаг Шилжилтийн индексийн Монгол Улсын 2022 оны үнэлгээний талаар, Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-ын “Монгол Улсын институтын шударга, ил тод байдал” төслийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг сайжруулах, гарын авлагыг орчуулах, шинжээчдийг бэлтгэх, үнэлгээ хийх зэрэг ажлуудыг багтаасан багц арга хэмжээний санал, танилцуулга, Төрийн албан дахь авлигын нөхцөл байдал, авлигын гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөл болон авлигаас урьдчилан сэргийлэх талаарх, санал танилцуулгын бэлтгэн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, танилцуулах арга хэмжээг авлаа.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэл болгон авлига, албан тушаалын гэмт хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж байна.

Тус байгууллагаас эрхлэн хэвлүүлдэг “Шударга ёс” онол, арга зүйн цуврал сэтгүүлийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгааг хийж, эрхлэн хэвлүүлснээс хойш хугацааны бүх дугаарыг [legaldata.mn \(https://legaldata.mn/b/1293\)](https://legaldata.mn)-д байршуулж, International Standard Serial Number (ISSN) буюу цувралаар хэвлэгддэг хэвлэлийн олон улсын стандарт дугаар (ISSN 2791-3619)-ыг албан ёсоор авлаа.

Дөрөв. Хяналт шалгалт, дүн шинжилгээний ажлын талаар:

4.1 Мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлын талаар:

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын 2021 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/-ийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав. Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас ХАСХОМ-ийн талаарх тайлан, мэдээг хүлээн авч, нэгдсэн дүн, мэдээг гаргалаа.

ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх хуулийн хугацаанд буюу 2022 оны 02 дугаар сарын 15-ны дотор улсын хэмжээнд нийт төрийн болон нутгийн захиргааны нийт 120 байгууллагын 47554 /цахимаар-42648, хэвлэмэл байдлаар-4906/ мэдүүлэг гаргагч мэдүүлгээ гаргаж бүртгүүлэхээс хуулийн хугацаанд 100 хувь мэдүүлгээ гаргаж баталгаажуулсан.

2021 онд Эдийн засаг, хөгжлийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Шүүхийн сахилгын хороо, Боловсролын ерөнхий газар, Стратегийн судалгааны хүрээлэн, Үндэсний итгэмжлэлийн төв зэрэг яам, агентлаг шинээр үүсэн байгуулагдаж, Мэргэжлийн хяналтын байгууллагаас Гаалийн ерөнхий газарт 365, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт 28 буюу нийт 393 албан тушаалтан шилжсэнтэй холбогдуулан 2021 оны ХАСХОМ-ээ шинэчлэн мэдүүлгээ гаргасан нийт мэдүүлэг гаргагчдын тоо өмнөх оноос 3861 нэгжээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр болон бусад 311 албан тушаалтнаас шинээр томилогдсон, сонгогдсон 158, их хэмжээний өөрчлөлт мэдүүлсэн 26 албан тушаалтан мэдүүлгээ хуулийн хугацаанд шинэчлэн мэдүүлжээ.

Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3-т заасан үндэслэл болон төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийтийг мэдээлэл авах боломжийг олгох зорилгоор Төрийн болон нутгийн захиргааны албан тушаалтны 2021 оны ХОМ-ийн хураангуйг <http://www.xacxom.iaac.mn> цахим хуудсанд нээлттэй байршууллаа.

4.2 Судалгаа, дүн шинжилгээний ажлын талаар

Мэдүүлгийн хяналт шалгалтыг эрсдэлд суурилан зохион байгуулж, үр дүнг тооцох хүрээнд 42,657 албан тушаалтны ХАСХОМ-ийн мэдээлэлд эрсдэл тооцлоо. Эрсдэлийн дүн шинжилгээгээр дунд болон түүнээс дээш эрсдэлтэй 6895 /16.2 хувь/, түүний дотор Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Боловсрол, шинжлэх ухааны яам, Гадаад харилцааны яам, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Эрүүгийн цагдаагийн алба, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Гаалийн ерөнхий газар, Замын-Үүд дэх гаалийн газар, УБТЗ ХНН, Монгол банк, Улсын Их Хурлын Тамгын Газар, Нийслэлийн ЗДТГ, Шүүхийн шинжилгээний хүрээлэн, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Баянгол дүүргийн Татварын хэлтэс, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Баянзүрх дүүргийн ЗДТГ зэрэг байгууллагын нийтийн албан тушаалтны ХАСХОМ өндөр хувийг эзэлж байгаа дүн гарав.

Төрийн болон төрийн өмчийн оролцоотой компани, аж ахуйн нэгж, түүний харьяа хараат болон охин компани нийт 74 компанийн ажлын байрны чиг үүрэгт дүн шинжилгээ хийхэд авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлтэй 404 албан тушаал байгаа нь тогтоогдов.

Иймд төсөв, хөрөнгө захиран зарцуулах, тодорхой үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, эрх олгох, цуцлах, түдгэлзүүлэх, төрийн тодорхой үйлчилгээг хэрэгжүүлэх бие даасан нэгжийг удирдаж, эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргах, гэрээ байгуулах, хяналт шалгалт явуулах, тендер сонгон шалгаруулалт зохион байгуулах зэргээр шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа удирдах болон эрх бүхий албан тушаалтныг тодорхойлж, компанийн дүрэмд тусган Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамруулах тухай зөвлөмжийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эрчим хүчний яам, Зам, тээврийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, “УБТЗ”, “Эрдэнэс тавантолгой” ХК, “Эрдэнэс Монгол” ХХК түүний харьяа байгууллагуудад хүргүүлэв. Ингэснээр дээрх чиг үүргийг хэрэгжүүлдэг 500 орчим албан тушаалтан мэдүүлэг гаргахаар боллоо.


4.3 Сургалт сурталчилгаа, мэдээлэл арга зүйн ажлын талаар:

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албан тушаалтны үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, гаргаж байгаа нийтлэг зөрчил, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, мэдүүлгийг бүртгэж хадгалах эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг мэргэшүүлэх, сурган дадлагажуулах, үйл ажиллагаанд нь тавих хяналтыг дээшлүүлэх, удирдах албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр сургалт, мэдээлэл, арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулав. ЭБАТ-уудыг мэдээлэл, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, дэмжлэг үзүүлэх зорилгоор цахимаар нэгдсэн группэд гарын авлага, зөвлөмж, мэдээлэл, зааварчилгаа, сурталчилгаа болон бусад цаг үеийн шинжтэй мэдээллийг тухай бүр тогтмол байршуулж, тэднээс ирүүлсэн асуулт, санал, хүсэлтэд хариулт өгч ажиллаж байна.

Тайлант хугацаанд төрийн байгууллагад ажиллаж байгаа нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах чиг үүргийг гүйцэтгэж байгаа эрх бүхий албан тушаалтнуудын 362 буюу 20 гаруй хувь нь өөрчлөгдөн томилогдсон тул тэднийг сургаж, мэргэшүүлэхэд анхаарч, 85 ЭБАТ-ыг сургалтад хамрууллаа.

Нийтийн албан тушаалтнуудад зориулсан сургалтын арга хэлбэрийг өөрчлөн, нийтлэг гарч буй алдаа зөрчлийн жишээ дээр ажиллуулах, хамтран ярилцах, санал солилцох хэлбэрээр сургалтыг зохион байгууллаа. Тайлант хугацаанд 29 удаагийн удаагийн /цахим, танхимаар/-д 37 байгууллагын 5597 нийтийн албан тушаалтныг хамруулан суралцуулсан өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 9.2 дахин, нийт сургалтад хамруулсан албан хаагчдын тоо 12.7 дахин өссөн өссөн үзүүлэлттэй байна.

Сургалтад оролцогчдын тоон үзүүлэлт



Мэдүүлэг гаргагч албан тушаалтан нь хуулийн хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлэх үүргийн талаарх сурталчилгааны шторкыг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах зорилгоор МҮОНТ, ТВ-9, Малчин зэрэг телевиз, Өдрийн сонин, Өнөөдөр сонин болон АТГ-ын цахим сайт, www.news.mn, www.ikon, www.zaluu.mn сайтуудтай хамтран ажиллав.

4.4 Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт, шалгалтын ажлын талаар:


2022 оны эхний хагас жилд шинээр хүлээн авсан 208, өмнөх оны үлдэгдэл 57, нийт 265 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгахгаас 244-г хянан шийдвэрлэж, 21 мэдүүлэг ажиллагаанд байна.

Нийт шалгасан мэдүүлгийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 140 нэгжээр буюу 1.1 дахин, хянан шийдвэрлэсэн мэдүүлэг 120 нэгжээр буюу 50.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар хот дах Гаалийн газар, Шивээхүрэн дэх гаалийн газар, Гашуунсухайт дахь гаалийн газрын удирдах албан тушаалтнууд, нийт 152 мэдүүлэг гаргагчийн мэдүүлэгт хяналт шалгалт хийлээ.

Тайлант хугацаанд шалгасан нийт мэдүүлгийн 188 буюу 77.0 хувийг төлөвлөгөөт хяналт шалгалтаар, 8 буюу 3.2 хувийг иргэний гомдол, мэдээллээр, 48 буюу 19.6 хувийг бусад хэлтэс, албадаас шилжүүлснээр хянан шалгасан байна.

Дүрслэл 2 Мэдүүлгийн хяналт шалгалтын тоон үзүүлэлт /өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал/



Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалтаар шалгасан мэдүүлгийн тоо өмнөх оны мөн үеэс 188 нэгжээр, гомдол мэдээллээр шалгасан мэдүүлгийн тоо 2 нэгжээр, бусад хэлтэс албадаас шалгуулахаар шилжүүлсэн мэдүүлгийн тоо 30 нэгжээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хяналт шалгалтаар нийт 61 албан тушаалтанд, үүнээс Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.1-д зааснаар 8 мэдүүлэг гаргагчид сануулах, мөн зүйлийн 13.8.2-т зааснаар 27 мэдүүлэг гаргагчид албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, 13.8.3-т зааснаар 21 мэдүүлэг гаргагчид албан тушаал бууруулах, эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, 13.8.4-т зааснаар 3 мэдүүлэг гаргагчид албан тушаалаас нь огцруулах буюу ажлаас халах, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үндэслэлээр 2 мэдүүлэг гаргагчид мөн албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах хариуцлага тооцох үндэслэл тогтоогдсон байна.

Иймд хууль заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шаардлага хүргүүлснээр тайлант хугацаанд “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК, “Дулааны 4 дүгээр цахилгаан станц” ТӨХК, “ТОСК” ТӨХК, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, Гаалийн ерөнхий газрын 42 мэдүүлэг гаргагчид холбогдох хариуцлагыг тооцсон тухай хариуг хүлээн аваад байна.

ХАСХОМ-ийн хяналт шалгалт /өмнөх оны мөн үетэй харьцуулбал/

Хамаарах хугацаа	ХАСХОМ					Хариуцлага тооцуулах үндэслэлтэй	Хариуцлага тооцсон	
	Өмнөх оны үлдэгдэл	Тайлант хугацаанд хүлээж авсан	Шалгавал зохих	Хянан шийдвэрлэсэн	Ажиллагааны үлдэгдэл			
2021	Эхний хагас жил	35	90	125	124	1 /0.8%/	33 /26.4%/	8 /25.0%/
2022		57	208	265	244	21 /8.0%/	61 /23.0%/	42 /69.0%/


Хяналт шалгалтаар 15 мэдүүлэг гаргагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хянах явцад Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үйлдэл, мэдээллийг шалгуулахаар тус газрын Мөрдөн шалгах хэлтэст шилжүүллээ.

4.5 Гомдол, мэдээллийн хяналт шалгалтын ажлын талаар:

2022 оны эхний хагас жилд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан 319 /өмнөх оны үлдэгдэл 39/, нийт 358 гомдол, мэдээллийг хянан шалгахад тайлант хугацаанд 314 гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн бөгөөд одоо 44 гомдол, мэдээлэл ажиллагаанд байна. Шийдвэрлэлт 87.7 хувьтай байна.

Хянан шалгасан гомдол, мэдээллээс 88 албан тушаалтанд холбогдох зөрчил тогтоогдож, үүнээс 22 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, хуульд заасан үндэслэлээр буцаасан 10, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэн эрх бүхий хэлтэст шилжүүлсэн 36, бусад байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн 39, гомдлоо буцаасан 5, зөрчил илрээгүй 123, Зөрчлийн тухай хуульд зааснаар шийтгэл ногдуулсан 1, бусад 12 байна.

Дүрслэл 3 Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт /өмнөх оны мөн үетэй харьцуулбал/



Хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлын талаар нийт гомдол гаргагчдын 64.0 хувьд албан бичгээр, 36.0 хувьд нь амаар /утсаар цахим шуудангаар/ хариу өгчээ.

Тайлант хугацаанд хүлээж авсан нийт гомдол, мэдээллийн 172 буюу 48.0 хувийг Улаанбаатар хотоос, 186 буюу 52.0 хувийг орон нутгаас ирүүлсэн байна. Тоон үзүүлэлт, мэдээллээс харахад аймгуудаас Баян-Өлгий аймгаас 40 буюу 11.2 хувь, Говь-Алтай аймгаас 15 буюу 4.2 хувь, Архангай аймгаас 19 буюу 5.31 хувь, Хөвсгөл аймгаас тус бүр 17 буюу 4.8 хувийг эзэлж байгаа нь бусад аймгаас өндөр үзүүлэлттэй байна. Иймд Баян-Өлгий аймагт гарч байгаа нийтлэг зөрчил, уг зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарах, удирдах албан тушаалтны ёс зүй, манлайлал, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр Баян-Өлгий аймгийн Засаг дарга Д.Бауыржан, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Мухамед зэрэг аймгийн удирдлагуудтай уулзаж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа мөрдөх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар санал солилцож, энэ чиглэлд хамтран ажиллахаар боллоо.

Иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн мөрөөр газар дээр нь буюу Хөвсгөл, Говь-сүмбэр, Дорноговь аймаг, Дорноговь аймгийн Замын-Үүд суманд ажиллаж холбогдох арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлэв.

Шалган шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн агуулгын хувьд албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлсэн 16.0 хувийг, хууль бус шийдвэр гаргаж, бусдад давуу байдал олгосон 20.5 хувийг, ашиг сонирхлын зөрчилтэй хууль бус томилгоо, шийдвэр гаргасан 21.0 хувийг, хууль бус томилгоо хийсэн 29.5 хувийг, бусад 13.0 хувийг тус тус эзэлж байна. Энэхүү үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал, хууль бус шийдвэр гаргаж бусдад давуу байдал олгосон зөрчил 1.8 хувиар өсч, албаны эрх мэдлээ урвуулсан хэтрүүлсэн зөрчил 1.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Гомдол, мэдээлэлд дурьдсан нөхцөл байдлыг хянан шалгаж, хууль зөрчсөн 22 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, хууль бус шийдвэрийг хүчингүй болгуулан, ашиг сонирхлын зөрчил үүсэх эсхүл олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэх нөхцөлийг үүсгэж байгаа талаар мэдэгдэж, анхааруулав.

Хяналт шалгалтын явцад хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, зөрчлийг давтан гаргахгүй байх, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, албан тушаалтны ёс зүй, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Байгаль, орчин аялал жуулчлалын яам, Соёлын яам, Боловсрол шинжлэх ухааны яам, Гаалийн ерөнхий газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Баянгол, Сүхбаатар Чингэлтэй дүүргийн Засаг дарга, Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Увс аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар зэрэг нийт 66 байгууллага албан тушаалтанд ажлын чиглэл, зөвлөмжийг хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

4.6 Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан талаар:

Тайлант хугацаанд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 8046 этгээдийн ХАСУМ-ийг хүлээн авснаас 7938 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж, холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн, 108 мэдүүлэг хянагдаж байна.

*Хянан шалгасан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг
/өмнөх оны мөн үетэй харьцуулбал/*

өхөбм	Хүлээн авсан	Хянасан	Үүнээс:				Үлдэгдэл	
			АСЗ үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй	АСЗ үүсэх нөхцөл байдлыг анхааруулсан	Илт ашиг сонирхлын зөрчил үүсэх	Хуульд зааснаар буцаасан		
2021	эхний хагас жил	6530	6472	5630/87.0%	626/9.7%	12/0.2%	204/3.1%	58 /0.9%
2022		8046	7938	7257/91.4%	583/7.3%	21/0.3	77/1.0%	108/1.3%

2022 оны эхний хагас жилд хүлээн авсан ХАСУМ-ийн тоо 2021 оны мөн үетэй харьцуулахад 1516 нэгжээр буюу 23.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт хүлээн авсан 8046 хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн 7128 буюу 88.6 хувийг цахим системээр, 918 буюу 11.4 хувийг хэвлэмэл хэлбэрээр хүлээн авч, хянан шийдвэрлэсэн байна.

Тав. Мөрдөн шалгах ажлын талаар:


5.1 Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл:

2022 оны эхний хагас жилд өмнөх оны үлдэгдэл 125, шинээр хүлээн авсан гэмт хэргийн талаархи 829, нийт 954 гомдол, мэдээллээс 165-ыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу харьяалах байгууллагад нь шилжүүлж, гэмт хэргийн шинжтэй 789 гомдол, мэдээллийг бүртгэлд оруулан шалгасан байна.

Гэмт хэргийн талаарх нийт 789 гомдол, мэдээлэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 313 буюу 32.8 хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 327 гомдол, мэдээлэл буюу 34.3 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 21 гомдол, мэдээлэл буюу 2.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, 128 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 86.6 хувьтай байна.


Тухайн онд шинээр хүлээн авч, мөрдөн шалгах ажиллагаа явуулан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаархи гомдол мэдээлэл 678 байгаа нь өмнөх оны мөн үеэс 65 нэгжээр буюу 10.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

*Шалгаж, шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл
/өмнөх оны мөн үетэй харьцуулбал/*




Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг холбогдсон албан тушаалын ангиллаар нь авч үзвэл: төрийн улс төрийн 124, төрийн захиргааны 217, төрийн тусгай 233, төрийн үйлчилгээний 90, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 95, бусад буюу хувийн хэвшил, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын 30 байна.

Дүрслэл 5 Гомдол мэдээлэлд холбогдох албан тушаалтны ангилал



Хүлээн авч шалгасан 789 гомдол, мэдээллээс 254 буюу 41.4 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, 283 буюу 46.1 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 25 буюу 4.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, 8.3 хувь буюу 51 гомдол, мэдээлэл ажиллагаанд байна.

*Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт
/өмнөх оны мөн үетэй харьцуулбал/*



Мөрдөн шалгах хэлтэст хүлээн авч шалгасан 789 гомдол, мэдээллийн 107 буюу 51.6 хувийг Улаанбаатар, 382 буюу 44.4 хувийг орон нутгийн прокурорын хяналтын харьяалалтай гомдол, мэдээлэл эзэлж байна.


5.2 Эрүүгийн хэргийн талаар:

Тайлант хугацаанд хуульд заасан харьяаллын 1246 үйлдэлтэй, 754 холбогдогчтой, 1046 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 13.2 хувиар өссөн байна. /2021 оны эхний хагас жилд 924 хэрэг/


Нийт шалгасан хэргийн 153 буюу 14.6 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай, 195 буюу 18.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай, 18 буюу 1.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 54 хэргийг нэгтгэн шалгаж, 10 хэргийг түдгэлзүүлж, одоо 616 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хэрэг бүртгэлтийн 534 хэрэг, мөрдөн байцаалтын 82 хэрэг байна.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 40.2 хувьтай, шүүхээр 82 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн байна.

Хэргийн шийдвэрлэлт
/өмнөх оны мөн үетэй харьцуулбал/



Ажиллагаанд байгаа хэрэг
/өмнөх оны мөн үетэй харьцуулбал/



Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйл хэсгээр ангилбал:

Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах / гэмт хэрэг-692 буюу 66.2 хувь,

Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл /Хахууль авах/ гэмт хэрэг-164 буюу 13.2 хувь,

Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл /Хахууль өгөх/ гэмт хэрэг-96 буюу 7.7 хувь,

Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/ гэмт хэрэг-14 буюу 1.1 хувь,

Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/ гэмт хэрэг-35 буюу 2.8 хувь,

Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйл /Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/ гэмт хэрэг-22 буюу 1.8 хувь,

Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/ гэмт хэрэг-22 буюу 2.1 хувь,

Бусад хэрэг 223 буюу 17.9 хувийг тус тус эзэлж байна.

Хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн 33 буюу 4.4 хувийг төрийн улс төрийн, 77 буюу 10.2 хувийг төрийн захиргааны, 42 буюу 5.6 хувийг төрийн тусгай, 52 буюу 6.9 хувийг төрийн үйлчилгээний, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 10 буюу 1.3 хувийг, 540 буюу 71.6 хувийг бусад этгээд эзэлж байна.

*Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан албан тушаалтан
/өмнөх оны мөн үетэй харьцуулбал/*




2022 оны эхний хагас жилд шалгагдсан гэмт хэргийн улмаас 2,061,324,104,812.00 /хоёр их наяд, жаран нэгэн тэрбум, гурван зуун хорин дөрвөн сая, нэг зуун дөрвөн мянга, найман зуун арван хоёр/ төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 1,235,701,691,027.44 /нэг их наяд хоёр зуун гучин таван тэрбум, долоон зуун нэг сая, зургаан зуун ерэн нэгэн мянга, хорин долоо/ төгрөгийн хохирлыг буюу 60.0 хувийг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 382,746,448,140.00 /гурван зуун наян хоёр тэрбум, долоон зуун дөчин зургаан сая, дөрвөн зуун дөчин найман мянга, нэг зуун дөч/ төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Хахуулийн 4,037,934,407.00 /дөрвөн тэрбум гучин долоон сая есөн зуун гучин дөрвөн мянга, дөрвөн зуун долоон мянга/ төгрөгийг хураан авч, улсын орлого болгосон.

Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2.1 дахин, хохирол нөхөн төлүүлэлт 13.9 дахин, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 3.4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

**Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт
/өмнөх оны мөн үетэй харьцуулбал/**



5.3 Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн талаар:

2021 оны эхний хагас жилд тус хэлтсээс мөрдөн шалгах ажиллагаа явуулж шүүхэд шилжүүлсэн хэргээс 44 эрүүгийн хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэж байсан бол 2022 оны эхний хагас жилд 82 хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэж, шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг өмнөх оныхоос 46.3 хувиар өссөн байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдийг дурдвал:

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын орлогч захирал Г, мөн газрын Техникийн хэлтсийн автоматжуулалт хариуцсан тэргүүлэх мэргэжилтэн Д нарт холбогдох, Гаалийн ерөнхий газрын харьяа Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын дарга М-д холбогдох, Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын Барилга байгууламжийн хэлтсийн дарга Ж, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Тамгын газрын дарга Б нарт холбогдох, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э-д холбогдох, Эрүүл мэндийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэргэжилтэн Ч, ахлах мэргэжилтэн Б, шинжээч О, Н, Н нарт холбогдох, Барилга, хот байгуулалтын яамны Бодлого төлөвлөлтийн газрын Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого, төлөвлөлт, төсөл, хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн Э нарт холбогдох, Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга У нарт холбогдох, “Автотээврийн Үндэсний төв” Төрийн өмчит үйлдвэрийн газрын Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Э нарт холбогдох зэрэг хэргүүд давж заалдах, хяналтын шатны шүүхээр тус тус эцэслэн шийдвэрлэгдээд байна.